



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/548

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн албаны тухай хуулийн 61 дугаар зүйлийн 61.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага болон аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт таван мянга, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон сум дундын эрүүл мэндийн төвд нэг мянга, аймгийн бусад эрүүл мэндийн байгууллагад гурван мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Засгийн газрын 2012 оны "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам батлах тухай" 150 дугаар тогтоолын нэмэгдэл, мөнгөн урамшлын хэмжээг тухайн байгууллагын үндсэн цалингийн сангийн 10 хувь байхаар тооцож ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3. Шинэчлэн тогтоосон төрийн албан хаагчийн хоол, унааны хөнгөлөлтийг 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Содномжамц/-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ